НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/586/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд<br>Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: М.Ундармаа<br>Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn<br>Аудитор: Л.Одонтуяа<br>Утас: 325093 Цахим хаяг: Odontuyal@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 02. 25 № 01/161

танай ____________-ны № ____________-т

БАЯНГОЛ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.НЭРГҮЙ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд "Анхан шатны шүүхийн байршил, тэдгээрийн нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно" гэж заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийг татан буулгаж тус шүүхтэй нэгтгэн, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийг байгуулсан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25 BGD HUD IHASh Shuuh.docx

02023591

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.BGD.HUD.IHAShShuuh.docx

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.

## 2.1 Аудит хийсэн 2024 оны санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,579,223.00** | **99,526,074.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,410,000.00 | 810,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 1,410,000.00 | 810,000.00 |
| **3121** | **Төгрөг** | 1,410,000.00 | 810,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,410,000.00 | 810,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,169,223.00 | 98,716,074.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 51,169,223.00 | 98,716,074.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,900,860.00 | 16,023,610.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 38,660,163.00 | 79,385,264.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,558,200.00 | 3,007,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,050,000.00 | 300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,062,241,128.42** | **2,140,663,917.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,062,241,128.42 | 2,140,663,917.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,021,716,853.42 | 2,100,627,142.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,594,577,407.74 | 1,594,577,407.74 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -116,703,767.64 | -168,447,801.84 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 71,350,078.14 | 87,350,078.14 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,883,384.95 | -25,166,726.95 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 572,960,632.01 | 529,545,994.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -188,892,396.63 | -145,418,776.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 282,669,946.62 | 361,985,790.22 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -178,955,128.38 | -137,634,102.80 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,333,500.00 | 3,333,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -924,333.48 | -1,287,521.04 |
| 39217 | Ном | 1,184,299.99 | 1,789,299.99 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40,524,275.00 | 40,036,775.00 |
| 39301 | Програм хангамж | 3,825,000.00 | 75,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,128,125.00 | 134,375.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 39,827,400.00 | 39,827,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,114,820,351.42** | **2,240,189,991.10** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,114,820,351.42** | **2,240,189,991.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,114,820,351.42 | 2,240,189,991.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 15,930,960.00 | 15,930,960.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 15,930,960.00 | 15,930,960.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,095,421,790.42 | 2,220,791,430.10 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,095,421,790.42 | 2,095,421,790.42 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 125,369,639.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,467,601.00 | 3,467,601.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,114,820,351.42** | **2,240,189,991.10** |

## 2.2 Аудит хийсэн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,108,645,393.00** | **7,214,201,282.04** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **626,771,193.00** | **184,886,882.04** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 626,771,193.00 | 184,886,882.04 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 608,633,493.00 | 174,627,682.04 |
| 120009 | Бусад орлого | 5,585,000.00 | 4,595,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,481,874,200.00** | **7,029,314,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,471,874,200.00 | 7,029,314,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,471,874,200.00 | 7,029,314,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,000,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,577,637,323.86** | **7,088,831,642.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,577,637,323.86** | **7,088,831,642.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,528,004,707.90 | 6,813,295,956.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,494,171,703.10 | 5,060,095,579.77 |
| 210101 | Үндсэн цалин | 2,185,272,402.87 | 3,127,933,325.05 |
| 210102 | Нэмэгдэл | 621,722,355.19 | 911,596,266.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 223,110,279.88 | 461,241,868.20 |
| 210104 | Урамшуулал | 464,066,665.16 | 559,324,119.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 432,153,853.36 | 642,867,681.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 290,874,868.36 | 405,525,238.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 35,270,459.53 | 85,303,538.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 26,565,100.17 | 25,339,803.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,771,066.88 | 25,339,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 70,672,358.42 | 101,359,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 77,378,617.95 | 288,060,952.89 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,148,137.67 | 35,303,766.97 |
| 210302 | Түлш, халаалт | 27,889,540.28 | 25,076,005.29 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,190,940.00 | 6,901,188.63 |
| 210304 | Байрны түрээс | 12,150,000.00 | 220,779,992.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 288,250,290.63 | 450,335,670.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 144,632,760.00 | 221,454,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,900,000.00 | 23,700,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 63,175,590.63 | 95,032,874.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,048,860.00 | 1,992,630.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 59,493,080.00 | 108,155,546.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 50,604,074.00 | 131,574,330.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,704,500.00 | 16,763,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 46,899,574.00 | 114,810,530.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 450,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 450,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 35,966,846.62 | 58,312,943.68 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,391,020.62 | 51,860,743.18 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,281,300.00 | 3,281,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 410,416.00 | 412,220.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 660,000.00 | 2,529,288.50 |
| 210807 | Газрын төлбөр | 103,110.00 | 97,392.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 149,479,322.24 | 181,598,798.36 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 149,479,322.24 | 181,598,798.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 49,632,615.96 | 275,535,686.11 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,420,000.00 | 112,420,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 99,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,420,000.00 | 13,020,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 41,091,815.96 | 163,115,186.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,091,815.96 | 163,115,186.11 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 120,800.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 120,800.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **531,008,069.14** | **125,369,639.68** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 40,960.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 40,960.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -40,960.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **530,967,109.14** | **125,369,639.68** |

## 2.3 Аудит хийсэн 2024 оны мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,481,874,200.00** | **7,029,874,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **560,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 560,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 560,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,481,874,200.00** | **7,029,314,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,471,874,200.00 | 7,029,314,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,471,874,200.00 | 7,029,314,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,000,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,435,154,695.00** | **6,949,115,495.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,435,154,695.00** | **6,949,115,495.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,385,522,079.04** | **6,673,620,308.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,494,171,703.10 | 5,060,095,583.52 |
| 210101 | Үндсэн цалин | 2,186,972,402.87 | 3,127,933,328.80 |
| 210102 | Нэмэгдэл | 621,722,355.19 | 911,596,266.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 223,110,279.88 | 461,241,868.20 |
| 210104 | Урамшуулал | 462,366,665.16 | 559,324,119.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 432,153,853.36 | 642,867,677.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 290,874,868.36 | 440,149,077.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 35,270,459.53 | 50,679,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 26,565,100.17 | 25,339,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,771,066.88 | 25,339,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 70,672,358.42 | 101,359,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 77,378,617.95 | 288,060,952.89 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,148,137.67 | 35,303,766.97 |
| 210302 | Түлш, халаалт | 27,889,540.28 | 25,076,005.29 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,190,940.00 | 6,901,188.63 |
| 210304 | Байрны түрээс | 12,150,000.00 | 220,779,992.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 289,606,630.63 | 465,941,721.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 148,149,650.00 | 224,453,370.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,950,000.00 | 21,950,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 63,175,590.63 | 99,036,874.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,048,860.00 | 1,992,630.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 55,282,530.00 | 118,508,847.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,346,000.00 | 7,660,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,346,000.00 | 7,660,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,540,224.00 | 149,045,930.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,540,400.00 | 31,846,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 49,999,824.00 | 117,199,930.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 450,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 450,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,375,050.00 | 59,498,443.68 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,799,224.00 | 51,138,243.18 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,281,300.00 | 3,281,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 411,416.00 | 412,220.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 660,000.00 | 4,437,288.50 |
| 210807 | Газрын төлбөр | 103,110.00 | 97,392.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 950,000.00 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 950,000.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,632,615.96** | **275,495,186.11** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,420,000.00 | 112,380,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 99,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,420,000.00 | 12,980,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 41,091,815.96 | 163,115,186.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,091,815.96 | 163,115,186.11 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 120,800.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 120,800.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **46,719,505.00** | **80,758,905.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **53,309,505.00** | **81,358,905.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **53,309,505.00** | **81,358,905.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 53,309,505.00 | 81,358,905.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 53,309,505.00 | 81,358,905.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-53,309,505.00** | **-81,358,905.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -6,590,000.00 | -600,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 8,000,000.00 | 1,410,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,410,000.00 | 810,000.00 |

## 2.4 Аудит хийсэн 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 15,930,960.00 | 3,467,601.00 | 1,564,454,681.28 | 00.00 | 1,583,853,242.28 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **15,930,960.00** | **3,467,601.00** | **1,564,454,681.28** | **00.00** | 1,583,853,242.28 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 530,967,109.14 | 00.00 | 530,967,109.14 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,930,960.00** | **3,467,601.00** | **2,095,421,790.42** | **00.00** | 2,114,820,351.42 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,930,960.00** | **3,467,601.00** | **2,095,421,790.42** | **00.00** | 2,114,820,351.42 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **15,930,960.00** | **3,467,601.00** | **2,095,421,790.42** | **00.00** | 2,114,820,351.42 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 125,369,639.68 | 00.00 | 125,369,639.68 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,930,960.00** | **3,467,601.00** | **2,220,791,430.10** | **00.00** | 2,240,189,991.10 |

## 2.5 Аудит хийсэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 7,232,914,400.00 | 6,867,359,213.89 | 365,555,186.11 | 94.9% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 7,232,914,400.00 | 6,867,359,213.89 | 365,555,186.11 | 94.9% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,917,448,400.00 | 6,754,979,213.89 | 162,469,186.11 | 97.7% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,205,379,300.00 | 5,060,095,583.52 | 145,283,716.48 | 97.2% |
| 210101 | Үндсэн цалин | 3,444,347,700.00 | 3,127,933,328.80 | 316,414,371.20 | 90.8% |
| 210102 | Нэмэгдэл | 1,242,250,800.00 | 911,596,266.85 | 330,654,533.15 | 73.4% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 340,748,000.00 | 461,241,868.20 | -120,493,868.20 | 135.4% |
| 210104 | Урамшуулал | 178,032,800.00 | 559,324,119.67 | -381,291,319.67 | 314.2% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 658,547,400.00 | 642,867,677.39 | 15,679,722.61 | 97.6% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 455,828,800.00 | 440,149,077.39 | 15,679,722.61 | 96.6% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 50,679,700.00 | 50,679,700.00 | 0.00 | 100.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,339,800.00 | 25,339,800.00 | 0.00 | 100.0% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 25,339,800.00 | 25,339,800.00 | 0.00 | 100.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 101,359,300.00 | 101,359,300.00 | 0.00 | 100.0% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 288,103,200.00 | 288,060,952.89 | 42,247.11 | 100.0% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,168,600.00 | 35,303,766.97 | -2,135,166.97 | 106.4% |
| 210302 | Түлш, халаалт | 25,079,600.00 | 25,076,005.29 | 3,594.71 | 100.0% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,075,000.00 | 6,901,188.63 | 2,173,811.37 | 76.0% |
| 210304 | Байрны түрээс | 220,780,000.00 | 220,779,992.00 | 8.00 | 100.0% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 466,551,500.00 | 466,546,721.41 | 4,778.59 | 100.0% |
| 210401 | Бичиг хэрэг | 223,800,000.00 | 224,453,370.00 | -653,370.00 | 100.3% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,953,500.00 | 21,950,000.00 | 3,500.00 | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 98,105,600.00 | 99,036,874.41 | -931,274.41 | 100.9% |
| 210404 | Ном, хэвлэл | 609,400.00 | 605,000.00 | 4,400.00 | 99.3% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 1,992,630.00 | 7,370.00 | 99.6% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 120,083,000.00 | 118,508,847.00 | 1,574,153.00 | 98.7% |
| **2105** | **Нормативт зардал** | 7,660,000.00 | 7,660,000.00 | 0.00 | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,660,000.00 | 7,660,000.00 | 0.00 | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 229,800,000.00 | 229,799,835.00 | 165.00 | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 44,000,000.00 | 43,998,505.00 | 1,495.00 | 100.0% |
| 210602 | Тавилга | 69,800,000.00 | 68,601,400.00 | 1,198,600.00 | 98.3% |
| 210604 | Урсгал засвар | 116,000,000.00 | 117,199,930.00 | -1,199,930.00 | 101.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 450,000.00 | 450,000.00 | 0.00 | 100.0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 450,000.00 | 450,000.00 | 0.00 | 100.0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 60,957,000.00 | 59,498,443.68 | 1,458,556.32 | 97.6% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 52,250,000.00 | 51,138,243.18 | 1,111,756.82 | 97.9% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,281,300.00 | 3,281,300.00 | 0.00 | 100.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 439,300.00 | 412,220.00 | 27,080.00 | 93.8% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 132,000.00 | 0.00 | 100.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,442,000.00 | 4,437,288.50 | 4,711.50 | 99.9% |
| 210807 | Газрын төлбөр | 412,400.00 | 97,392.00 | 315,008.00 | 23.6% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 315,466,000.00 | 112,380,000.00 | 203,086,000.00 | 35.6% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 315,466,000.00 | 112,380,000.00 | 203,086,000.00 | 35.6% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 302,466,000.00 | 99,400,000.00 | 203,066,000.00 | 32.9% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,000,000.00 | 12,980,000.00 | 20,000.00 | 99.8% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 7,232,914,400.00 | 6,867,359,213.89 | 365,555,186.11 | 94.9% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 7,232,914,400.00 | 6,867,359,213.89 | 365,555,186.11 | 94.9% |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 7,232,914,400.00 | 6,867,359,213.89 | 365,555,186.11 | 94.9% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 1,410,000.00 | -1,410,000.00 | 0.0% |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 810,000.00 | -810,000.00 | 0.0% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 108 | 108 | 0 | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 3 | 3 | 0 | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 95 | 95 | 0 | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 | 0 | 100.0% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **108** | **108** | 0 | 100.0% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 54 | 54 | 0 | 100.0% |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 26 | 26 | 0 | 100.0% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 28 | 28 | 0 | 100.0% |

## Гурав. Аудитын илрүүлэлт.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 100,695.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

**Залруулсан алдаа:**

- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 48,905.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн орлогоор тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 51,790.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 38,626.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 38,456.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 170.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 38,626.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 30,039.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас 8,100.0 мянган төгрөгийн бараа, материал худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u> :* Өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

2. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 30,356.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахдаа худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй, шууд худалдан авах зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.12-д “Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн

санал дуудаж зохион байгуулж болно" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь :* Шууд худалдан авах зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

### 5.2 Зөвлөмж

Гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн цахим архивчийн цалингаас суутгасан шимтгэлийн зардлыг НДШ-ийн зардлаас төлүүлж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заастай тус тус нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Бусдаар гүйцэтгүүлсэн зардлаас гэрээт ажилтны цалинтай холбоотой зардлыг гаргаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс ү

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн орлогоор тайлагнасан. | 1 | 48,905.0 | - | - | 1 | 48,905.0 | 1 | 48,905.0 | - | - | - | - |
| МГТ-нд Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнг дутуу илэрхийлсэн. | 1 | 51,790.00 | - | - | 1 | 51,790.00 | 1 | 51,790.00 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **100,695.0** | **-** | **-** | **2** | **100,695.0** | **2** | **100,695.0** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Гэрээт цахим архивчийн НДШ-ийг цалин, Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас төлүүлсэн. | 1 | 170.2 | | | | | 1 | 170.2 |
| Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагаас бараа материал худалдан авсан. | 1 | 8,100.0 | | | 1 | 8,100.0 | | |
| Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй. | 1 | 30,356.0 | - | - | 1 | 30,356.0 | - | - |
| Дүн | **3** | **38,626.0** | - | - | **2** | **38,456.0** | 1 | **170.2** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж үйлчилгээний ажилчдад нормын хувцас авсан. | 1 | 6,800.0 | | | 1 | 6,800.0 | | |
| Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд хүсэлт илгээж,  худалдан авалт хийгээгүй байна. | 1 | 45,082.8 | - | - | - | - | 1 | 45,082.8 |
| Дүн | **2** | **51,882.8** | - | - | 1 | 6,800.0 | **1** | **45,082.8** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 143/А0271309 Улаанбаатар хот

НТАГ-2025/586/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 30,356,000.00 (гучин сая гурван зуун тавин зургаан мянган) төгрөгийн бараа, материал худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

**Иймд** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *“Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт1 ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын дарга С.Нэргүй, нягтлан бодогч Х.Баярсайхан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:**

АУДИТОР Л.ОДОНТУЯА

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043544

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 144/А0271309 Улаанбаатар хот
НТАГ-2025/586/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 8,100,000.00 (найман сая нэг зуун мянган) төгрөгийн компьютерын дагалдах хэрэгслийг өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлийн байгууллагаас худалдан авалт хийгээгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын дарга **С.Нэргүй, нягтлан** бодогч Х.Баярсайхан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

АУДИТОР Л.ОДОНТУЯА

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043546

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 145/А027(309 Улаанбаатар хот
НТАГ-2025/588/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шүүгчдэд нөмрөг авах зардлаас 6,800,000.00 (зургаан сая найман зуун мянган) төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Иймд** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын дарга С.Нэргүй, нягтлан бодогч Х.Баярсайхан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АУДИТОР Л.ОДОНТУЯА

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043518